

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ



1993 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ

(хэсэгчлэн авав)

36 дугаар зүйл. Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагч, иргэний эрх зүйн баталгаа

2. Улсын хилд хил хамгаалах албан үүргээ биечлэн гүйцэтгэж байгаа иргэн гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно.

[/Энэ хэсгийг 1994 оны хуулиар хүчингүй болгоод 1996 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/](#)

3. Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг тус тус улсаас олгоно.

4. Улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн гэр бүлийг тэргүүн ээлжинд ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.

Хилийн суман, харуулд алба хааж байгаа офицер, ахлагч хүнсний хангамж үнэгүй эдэлнэ. Энэхүү хүнсний хангамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

[/Энэ өгүүлбэрийг 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

5. Хилийн тусгай анги, салбарт алба хааж байгаа офицер, ахлагч тэдний гэр бүлийг ээлжийн амралтаараа /нөхөр, эхнэрийн/ нутагтаа амарвал 2 жилд 1 удаа ирэх, очих унааны зардлыг улсаас олгоно.

6. Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн суманд 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн хороонд 35 хувь, нийслэл, аймгийн төв, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн хороо, агаарын довтолгооноос хамгаалах салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.РИНЧИНДОРЖ